



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/274

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлэхэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шатрын их мастер Төрмөнхийн Мөнхзулын нэрэмжит өсвөрийн аварга шалгаруулах "Оюунлаг иргэн-Бидний ирээдүй – 2023" шатрын тэмцээн Хэнтий аймгийн Батноров суманд зохион байгуулахтай холбогдуулан түүнд хүндэтгэл үзүүлэхэд 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Монгол үндсэний спортын уламжлалт соёлыг дээдэлж, орон нутагт зохион байгуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх" зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

04
16/24
Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 28-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ХӨРӨНГИЙН ТООЦОО

Д/д	Зардлын тооцоо	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хүндэтгэл үзүүлэх	1	5.000.000	5.000.000
	Нийт дүн			5.000.000